

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР  
ТУТМЫН ТОЙМ**

2015.06

**Үзүүлэлтүүд:**

<b>ДНБ 4.4%</b>	<b>ГШХО 5-р сард 28.4 сая ам.доллар</b>	<b>Төсвийн тэнцэл (534.9) тэр бум төгрөг</b>	<b>Инфляци 7.3%</b>	<b>Чанаргүй зээл 774 тэрбум төгрөг</b>	<b>Валютын нөөц 1591 сая ам.доллар</b>
Өсөлтөнд ХАА салбар 9.2%, аж үйлдвэр, барилгын салбар 13.1%, үйлчилгээний салбар 3.3%-иар өссөн нь нөлөөлжээ.	Цэвэр ГШХО 5-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 сая ам.доллараар өсч, өмнөх сараас 8.9 сая ам.доллараар буурч 28.4 сая ам.доллар болов.	Төсвийн орлого 2.64 их наяд төгрөг, зарлага 3.17 их наяд төгрөг болж тэнцэл 534.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 7.3 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 35.3 тэрбум төгрөг буюу 4.8%-иар өсч <b>774 тэрбум төгрөг</b> хүрэв.	Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 25.5 хувь буюу 323.7 сая ам.доллараар өсч 1591 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш

**1903.3**



Орон сууцны үнийн индекс

**1.14**

Өмнөх сараас 2.368%-иар, өмнөх жилээс 8.399%-иар тус бүр буурлаа.



Монголбанкны бодлогын хүү

**13%**




Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зарлиг гаргаж, олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн ээжүүдийн төлөөлөл болох 21 эхэд 6-р сарын нэгэнд "Алдарт эх" нэг, хоёрдугаар одон гардуулав.

**Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ**

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.

Эх сурвалж: УСХороо



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
<b>Нийт</b>	<b>27564</b>	<b>3 251 685</b>	<b>25 569</b>	<b>2 719 437</b>	<b>10 822</b>	<b>3 874 629</b>

Эх сурвалж: УСХороо


**ДНБ**

ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний улиралд 2.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 119.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар өслөө. Үүнд ХАА-н салбар 9.2 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 13.1 хувь, үйлчилгээний салбар 3.3 хувиар тус тус өссөн нөлөөлжээ.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 6-р сард 2.64 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 3.17 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 534.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 294.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Төсвийн орлогын 88.6% татварын, 11.3% татварын бус, 0.1% бусад орлогуудаас бүрджээ.




**Валютын хани**

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 1903.29 төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 78.6 төгрөг буюу 4.3 хувь суларч, өмнөх сараас 36 төгрөгөөр буюу 1.9 хувиар чангарсан байна.



**Инфляци**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны 6-р сард өмнөх сарынхаас 0.1%-иар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 7.3% өслөө. Индекс өмнөх сарынхаас 0.1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.4%, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 0.3% буусан нь голлон нөлөөлжээ.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны тавдугаар сарын байдлаар 1591 сая ам.доллар байв. Энэ нь өмнөх сараас 25.5% буюу 323.7 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 3.6 хувь буюу 14 сая ам.доллараар, оны эхнээс 0.8% буюу 58.9 сая ам.доллараар тус тус буурсан байна.



\* Эх сурвалж Монголбанк

**MSE-20 индекс**

Үнэт цаасны арилжаагаар 2015 оны эхний хагас жилд 587.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 19.6 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 453.3 тэрбум төг буюу 4.4 дахин өсч, арилжигдсан үнэт цаас 10.5 сая ш буюу 34.9 хувиар буурсан байна. ТОП-20 дундаж индекс 2015 оны 6 дугаар сард 14591.2 болж, өмнөх сарынхаас 1786.0 нэгжээр өсчээ. Хөрөнгийн бирж үйл ажиллагаа явуулж байгаа ХК-иудын үнэт цаасны нийт үнэлгээ 6 дугаар сард 1.4 их наяд төг болж, өмнөх сарынхаас 154.6 тэрбум төг буюу 12.3 хувиар өсчээ.



**Мөнгө**

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны эхний хагас жилд 10.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 201.8 тэрбум төгрөг буюу 2.1%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 65.7 тэрбум төгрөг буюу 0.7%-иар буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 755.8 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 37.9 тэрбум төгрөг буюу 4.8%, өнгөрсөн оны мөн үеэс 104.2 тэрбум төгрөг буюу 12.1%-иар буурсан байна.



**Хадгаламж**

Нийт хадгаламж 2015 оны 6-р сард 7.3 их наяд төгрөг болж, өнгөрсөн сараас 190.3 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар өсчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 172.1 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж өсөхөд төгрөгийн хадгаламж 1.7 хувиар буюу 89.9 тэрбум төгрөгөөр өсч, валютын хадгаламж 5.2 хувиар буюу 100.5 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.



**Зээл**

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны 6-р сарын байдлаар 11.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 222.2 тэрбум төгрөг буюу 1.8%-иар, өмнөх оны мөн үеэс 354.4 тэрбум төгрөг буюу 2.9%-иар тус тус буурчээ. Харин чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 774 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.8% (35.3 тэрбум төгрөг)-иар, өнгөрсөн оны мөн үеэс 36.5% (206.9 тэрбум төгрөг) өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 6.5%-ийг эзэлж байна.



**Ипотекийн зээл**

2015 оны 6-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 2 хувь (64.2 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 30.8 хувь (752 тэрбум төгрөг) - иар нэмэгдэж нийт 3.19 их наяд төгрөгт хүрэв. Зуравдугаар сард нийт 1567 зээлдэгчид 100.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 72412-д хүрлээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.3 хувь нь төгрөгийн, 1.7 хувь нь гадаад валютын зээл байгаа бөгөөд нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байна




\* Эх сурвалж Монголбанк

**Гадаад худалдаа**

**Гадаад худалдаа**


2015 оны 6-р сард худалдааны нийт бараа эргэлт 4208.9 сая ам.доллар, үүнээс экспорт 2370.2 сая ам.доллар, импорт 1838.7 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 531.5 сая ам.долларын ашигтай гарлаа. Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 109.8 сая ам.доллар буюу 4.4%-иар буурахад эрдэс бүтээгдэхүүний экспорт 158.5 сая ам.доллар, нэхмэл бүтээгдэхүүнийх 53.6 сая ам.доллараар буурсан нь нөлөөлсөн бол импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 762.0 сая ам.доллар буюу 29.3%-иар буурахад эрдэс бүтээгдэхүүний импорт 241.7 сая ам.доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 145.0 сая ам.доллар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 179.1 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөө.



\* Эх сурвалж ҮСХ, МБ

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2015 оны тавдугаар сард 28.4 сая ам.долларын эерэг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 18 сая ам.доллараар өсч, өмнөх сараас 8.9 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. 5-р сард МУ-аас гадаадагшаа хийгдсэн хөрөнгө оруулалт 1.6 сая ам.доллар байсан бол МУ-д гадаадаас 30 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.



\* Эх сурвалж МонголБанк

**Сарын онцлох үйл явдал**

- 06.08-06.10** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Европын Парламентын Ерөнхийлөгч Мартин Шульцийн урилгаар 2015 оны 6 дугаар сарын 8-10-нд Франц улсын Европын Парламентад албан ёсны айлчлал хийлээ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Европын Парламентын Ерөнхийлөгч М.Шульц, Европын Комиссын Ерөнхийлөгч Ж.К.Юнкер нартай тус тус уулзаж, Монгол Улс, Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх боломжийн талаар ярилцан санал солилцжээ.
- 06.18** Монголын бизнесийн дээд хэмжээний уулзалт 6-р сарын 18 – 20-ний өдрүүдэд Их тэнгэр цогцолборт боллоо. Гадаад, дотоодын бизнесийн салбарын 400 гаруй зочид төлөөлөгч оролцсон энэ дээд хэмжээний уулзалтыг МУ-ын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж нээж, эдийн засгийн салбарт ахиц гаргахуйц төлөвлөгөөт ажлуудын тухай болон хувийн хэвшлийг хөгжүүлэх асуудлаар үг хэллээ.
- 06.22** “Таван толгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг мэдээлэл хийлээ.
- 06.24** Орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийг 10 хувь болгож, 20 хувьд нь Засгийн газраас баталгаа гаргахаар Засгийн газрын ээлжит хуралдаанаар шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, дундаж орлоготой буюу тус зээлийн шалгуурт тэнцсэн зорилтот бүлгийн иргэд орон сууц худалдан авахдаа урьдчилгаа төлбөрийнхөө 10 хувийг өөрсдөө төлж, үлдэгдэл 20 хувьд нь төр баталгаа гаргана.
- 06.28-06.30** Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн урилгаар Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч У Тейн Сейн энэ 6 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийлээ.

**Тойм**

“Таван толгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгээр ахлуулсан ажлын хэсгийнхэн “Таван толгойн орд газрыг ашиглахад их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагагүй гэсэн дүгнэлт гаргалаа.

Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Таван толгой” компанийн агуулахад 2.3 сая тонн нүүрс, хөрс хуулж олборлоход бэлэн хоёр сая тонн нүүрс байгаа бөгөөд нийт 140 сая ам.долларын үнэлгээ бүхий нүүрсний нөөц нь “Чалко”-гийн 142 сая ам.долларын өрийг дарахад хүрэлцэхээр байгаа. Тус компани нүүрсээ уурхайн амнаас тээвэрлэж байгаа ба авто зам нь хүнд даацын зам бус учир худалдан авагч, тээвэрлэгч компаниуд алдагдал хүлээж байгаа аж. Түүнчлэн нүүрсний гадаад зах зээл өдөр тутам унаж байгаа учир жижиг Таван толгой, Эрдэнэс таван толгой аль аль нь борлуулалт буурсан дүнтэй байгаа аж. Цаашид нүүрсний үнэ олон улсын зах зээлд унах төлөвтэй байгаа тул хямд өртгөөр олборлолт тээвэрлэлтийг хийх нь чухал болжээ. Үнэ нэмэгдүүлж байгаа хүчин зүйл нь тээвэрлэлт. Иймд төмөр замаа ашиглалтад оруулах шаардлагатай байна гэж ажлын хэсгээс үзжээ.

